



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 0101

Майхан

Ж.Лхагвадоржийг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.22 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жадамбын Лхагвадоржийг Засаг даргын орлогчийн үүрэгт ажлаас 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн чөлөөлсүгэй.
2. Ажил хүлээлцэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч: М.Отгонбат (Санхүү албаны дарга)

Гишүүд: Г.Буянтогтох (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)

Г.Оюун (Нярав-үйлчлэгч)

3. Ж.Лхагвадоржтой холбогдох тооцоог хийж дуусгахыг Нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.АДЪЯАТОГТОХ

10000000001



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 8/02

Майхан

О.Ганпүрэвийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.22, Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын орлогчоор Очирдоржийн Ганпүрэвийг 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. О.Ганпүрэвийн үндсэн цалинг дээрх өдрөөс эхлэн 753952 (долоон зуун тавин гурван мянга есөн зуун тавин хоёр) төгрөгөөр тогтоож, албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг үндсэн цалингийн 30 хувиар тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д зөвшөөрсүгэй.

3. Засаг даргын орлогчийн ажлыг хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Бат-Эрдэнэ- Засаг даргын Тамгын газрын дарга  
Гишүүд: Я.Дагмидмаа- Нягтлан бодогч  
Т.Цэндмаа- Архив, бичиг хэргийн эрхлэгч

4. Ажлыг хүлээлцүүлэн танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.АДЪЯАТОГТОХ

1000000000



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 5/03

Майхан

Б.Соёлмааг ажлаас чөлөөлөх тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.9 дэх заалт, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Бадарчийн Соёлмаа нь өндөр настны тэтгэвэрт гарах хүсэлтээ өгсөн тул 2022 оны 03 дугаар сарын 07-ний өдрөөс эхлэн ажлаас чөлөөлсүгэй.

2. Б.Соёлмаагийн тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой материалыг бүрдүүлж хүргүүлэхийг Эрүүл мэндийн төвийн Нягтлан бодогч (Х.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.АДЪЯАТОГТОХ

1060000000



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 19 өдөр

Дугаар 5/04

Сант сум

Цалингийн нэмэгдлийг зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүү албаны дарга Мөнхнасангийн Отгонбат нь орон нутгийн хөгжлийн сан хариуцан ажиллаж, үр дүнгээр үндсэн цалингийн 20 хувийн нэмэгдэл авч байсныг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны улсын байцаагчийн албан шаардлагын дагуу 2022 оны 08 дугаар сараас эхлэн цуцалсугай.

2. Дээрх нэмэгдлийг 2022 оны 08 дугаар сараас эхлэн олгохгүй байхыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 13-ний өдрийн А/96 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Б.АДЪЯАТОГТОХ



1060000000